



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.1, 9.4, 9.7 дахь хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Найдалаа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд:

Х.Болормаа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Д.Ганмаа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

С.Зулпхар

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Т.Мөнхсайхан

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Г.Хосбаяр

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Л.Энхнасан

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Д.Энхтуяа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

С.Эрдэнэбат

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг (Б.Найдалаа)-т зөвшөөрсүгэй.

4.Холбогдох санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Найдалаа)-т даалгасугай.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА


Б.НАЙДАЛАА



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2025 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот



1.1. Ажлын хэсгийн зорилго

Эрүүл мэндийн даатгалын санг үр ашигтай удирдах, даатгалаар санхүүжих эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр санал дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулах.

1.2. Зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын засаглал, тогтолцоо, эрүүл мэндийн даатгалын санг удирдахтай холбогдсон харилцаанд дүн шинжилгээ хийх.

2. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт, стратегийн худалдан авалтын хэрэгжилтийн нөхцөл байдалтай танилцаж, дүгнэлт хийх.

3. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай зүйл, заалтыг тодорхойлох.

4. Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон холбогдох бусад эрүүл мэндийн салбарын хууль хоорондын зөрчлийг тодорхойлох.

5. Олон улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, туршлага судлах.

6. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулж, хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

1.3. Хугацаа, үе шат

Ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 24-нөөс 2026 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- Засгийн газар, яам, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, агентлаг, холбогдох нэгж, албан тушаалтан, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагуудаас эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, төсөв санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байгаа тусламж үйлчилгээтэй холбоотой баримт, тоон мэдээлэл цуглуулах, тайлан мэдээ гаргуулах;

- холбогдох байгууллагуудаас тодруулга авах, тайлбар сонсох;

- хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах;

- шаардлагатай тохиолдолд тухайн хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулах зэрэг үе шаттайгаар ажиллана.

---oOo---